

БАТЛАВ
“ДЦС-4” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ТӨМӨРХУЯГ/



БАТЛАВ.
АКВАТЕРМ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
.../О.БАТНАРАН/



ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ, ХЭРЭГЛЭХ ГЭРЭЭ

№.....

1/2020-566

2020 оны ...-р сарын ...-ны өдөр

Нэг талаас “ДЦС-4” ТӨХК-ийг төлөөлж Бизнес үйлчилгээ эрхэлсэн дэд захирал Б.Сандуйжав /цаашид хангагч гэх/, нөгөө талаас Акватерм ХХК-ийн үйлдвэрийн дарга А.Гансүх /цаашид хэрэглэгч гэх/ нар Монгол улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, Дулааны эрчим хүчийг хэмжих тооцох дүрэм, Холболтын журамын заалтуудыг үндэслэн 2020 оны 11-р сарын 01-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрийг дуустал хугацаатай дор дурьдсан нөхцөлтэйгээр энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав. Гэрээг үргэлжлүүлэн сунгах эсвэл шинээр байгуулах тухай хэлцэл явагдаж байх хугацаанд энэхүү гэрээг мөрдөнө.

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Хэрэглэгчийн захиалсан дулааны эрчим хүчийг
 - Халаалт,
 - Халуун усыг энэхүү гэрээний хавсралтанд заасан тоо хэмжээнд хангах, хэрэглэх, төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн хийх, гэрээ байгуулагч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, шаардлагатай бусад нөхцлүүдийг харилцан тохиролцов.
- 1.2 Энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдон гарах, гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг “Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгчийн хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийн заалтуудыг үндэслэн зохицуулна.
- 1.3 Гэрээг хавсралтын хамт 3 хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр нь хуулийн хүчин төгөлдөр байна.

Хоёр. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа дулааны тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор дараах эрх, үүрэгтэй.
 - 2.1.1 Захиалгын хуудсанд заасан стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр хангагдах
 - 2.1.2 Дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагааны талаар хангагч талын холбогдох албан тушаалтанд мэдээлэл өгөх, санал хүсэлт, өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх
 - 2.1.3 Стандартын шаардлага хангаагүй дулааны эрчим хүч нийлүүлсэн тохиолдолд хоёр талын батаалгаажуулсан акт баримтыг үндэслэн учирсан хохирлоо нэхэмжлэх
 - 2.1.4 Гэрээнд өөрчлөлт оруулах бол энэ тухай хүсэлтийг хангагч талд бичгээр гаргаж шийдвэрлүүлэх
 - 2.1.5 Хэрэглэгч халаалтын бус хугацаанд дулааны эрчим хүчээр хангуулах эрхтэй.
- 2.2 Хэрэглэгч энэхүү гэрээгээр дараах үүргийг хүлээнэ.
 - 2.2.1 Хэрэглэгч захиалсан дулааны эрчим хүчийг худалдан авч Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифын дагуу төлбөрийг төлөх үндсэн үүрэг хүлээнэ.
 - 2.2.2 Дулааны эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах

- 2.2.3 Өөрийн эзэмшлийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах, ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах, тоног төхөөрөмжийн тохируулга, тооцоолол, хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, дулааны шугамын буцах усны температурыг зөвшөөрөгдөх хэмжээнд барих
- 2.2.4 Хэрэглэгч дулааны тоолуурын ажиллагаа алдагдсан, түүнд гэмтэл гарсан болон гарч болзошгүй нөхцөл байдал үүссэн үед хангагч талд яаралтай мэдэгдэх ба хэрэглэгчийн буруугаас тоолуур, тооцооны хэмжих хэрэгсэлд эвдрэл гэмтэл учруулсан нөхцөлд учирсан хохирлыг барагдуулах
- 2.2.5 Дулааны шугам, тоног төхөөрөмжид дулаан хангамжийн горимд нөлөөлөхүйц гэмтэл саатал гарвал хангагч талд нэн даруй мэдэгдэж үндсэн сүлжээнээс тусгаарлах арга хэмжээ авах
- 2.2.6 Хангагч талаас олгогдсон техникийн нөхцөлийн дагуу өөрийн эзэмшлийн дулааны шугам тоноглолоос шинээр хэрэглэгч холбуулах үүрэгтэй бөгөөд өөрийн шугамаас хэрэглэгч холбуулах үйл ажиллагаанаас ашиг олох зорилгоор бизнесийн үйл ажиллагаа явуулахгүй байх.
- 2.2.7 Хэрэглэгчийн хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг, үл хөдлөх хөрөнгийн эзэмшигч өөрчлөгдсөн бол ажлын 5 хоногийн дотор хангагч талд албан ёсоор мэдэгдэж, өөрчлөлтийг гэрээнд тусгуулах
- 2.2.8 Үл хөдлөх хөрөнгө эзэмшигч нь өөрийн эзэмшлийн газар, байшин барилгаа бусдад түрээслүүлэх, эзэмшүүлэх, худалдахдаа хэрэглэсэн эрчим хүчний тооцоогоо бүрэн дуусгаж, гэрээг дуусгавар болгосон байна. Хэрвээ гэрээ дуусгавар болгоогүй нөхцөлд үүссэн төлбөрийн төлөгдөөгүй дүнг гэрээ хийсэн иргэн, хуулийн этгээд хариуцан барагдуулах
- 2.2.9 Шинээр баригдах, өргөтгөл шинэчлэл хийх барилга байгууламжинд дулааны эрчим хүч авах, ачааллыг өөрчлөх болон халаалтын системийн техникийн шийдлийг өөрчлөх, шинэчлэл хийх тохиолдол бүрт хангагчаас техникийн нөхцөл шинээр авах
- 2.2.10 Хэрэглэгч тогтоосон хугацаанаас цааш үргэлжлүүлэн дулааны эрчим хүчээр хангагдах хүсэлтэй бол хангагчид албан бичгээр мэдэгдэж, хангагчийн төлөөлөгчийг байлцуулан хаах, нээх үйлдлийг гүйцэтгэнэ.
- 2.2.11 Хангагчийн эрх бүхий ажилтныг орон байрандаа саадгүй нэвтрүүлэх
- 2.2.12 Хэрэглэгч гэрээ шинээр байгуулах болон дулааны эрчим хүчний хэрэглээний тоо хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд дулааны эрчим хүчний захиалгыг хангагчид гаргаж өгөх
- 2.2.13 Хэрэглэгч нь Эрчим Хүчний Зохицуулах Хорооны боловсруулсан аргачлалын дагуу төлбөрт үйлчилгээг хийлгэж болно.

ГУРАВ. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр дүйлд заасныг хэрэгжүүлэх дараах эрх, үүрэгтэй байна.
 - 3.1.1 Эрчим хүчний тухай хуулийн дагуу “халаалтын улирал”-д хэрэглэгчийг дулааны эрчим хүчээр хангана. Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу хэрэгцээний халуун усаар хангаж болно.
 - 3.1.2 Хэрэглэгчийн шугам хоолой, худаг, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, хяналт тавих зохилгоор барилга байгууламжинд нэвтрэх, гэрээний үүргийн биелэлтийг шалгаж дүгнэх үед зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгуулах мэдэгдэл өгөх, нөхөн төлбөр тавих, алданги тооцох зэрэг хариуцлага тооцож, хүлээлгэх ба шаардлагатай тохиолдолд зөрчлийг арилгах хүртэл хугацаанд дулааны эрчим хүчний хангамжийг түдгэлзүүлэх
 - 3.1.3 Хэрэглэгч гэрээнд болон актанд заасан хугацаанд дулааны төлбөрөө төлөөгүй бол эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг хэрэглэгч хариуцна.
 - 3.1.4 Диспетчерийн үндэсний төвөөс тогтоосон дулааны эрчим хүчийг түгээх горим, параметрийг мөрдөж ажиллах

- 3.1.5 Хангагч дулаан дамжуулах шугамын засвар үйлчилгээ, тохируулга хийх үедээ хэрэглэгчид 24-өөс доошгүй цагийн өмнө зогсолтын тухай мэдэгдэл өгнө
- 3.1.6 Дулаан дамжуулах үндсэн тоноглол, шугаманд гарсан эвдрэл, гэмтлийн улмаас дулаан нийлүүлэх боломжгүй нөхцөл үүссэн үед хэрэглэгч талд үүссэн нөхцөл байдал, түүний үргэлжлэх хугацааны тухай нэн даруй мэдэгдэнэ.
- 3.1.7 Энэхүү гэрээг үндэслэн жил бүрийн халаалтын улирлын эхэнд дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, шугам тоноглолын зураг төсөл, техникийн нөхцлийн шаардлага хангаж дулааны болон бусад үйлчилгээний төлбөрийн үлдэгдэлгүй, дулааны эрчим хүчний захиалгаа үнэн зөв тооцож ирүүлсэн хэрэглэгчийг дулааны сүлжээнд холбох, хангах
- 3.1.8 Хангагч дулаан хангамжийн талаарх хэрэглэгчийн гаргасан санал хүсэлт, өргөдлийг түргэн шуурхай, тухайн өдөрт багтааж шийдвэрлэх

ДӨРӨВ. ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦОХ НӨХЦӨЛ

- 4.1 Талууд дулааны эрчим хүчний тооцоонд ЭХЗХ-ны баталсан үнэ тарифыг мөрдөх бөгөөд тарифт үнийг өөрчилсөн тохиолдолд заасан хугацаанаас эхлэн төлбөр тооцоондоо мөрдөнө
- 4.2 Дулааны эрчим хүчний тооцоог тоолуураар хийж байгаа хэрэглэгчийн хэрэглэсэн дулааны эрчим хүчний тоо хэмжээн дээр дулааны шугамын алдагдлыг 5%-аар нэмж тооцно.
- 4.3 Хэрэглэгч тоолуурын заалт үндэслэн дулааны эрчим хүчний төлбөрийг сар бүрийн 25-ны дотор хангагчийн sales@tpp4.mn цахим /и-мэйл/ хаягаар хэрэглэгчийн гэрээнд заасан албан ёсны цахим хаягт илгээнэ. Цахим шуудангаар илгээсэн өдрөөр төлбөрийг нэхэмжилсэнд тооцно.
- 4.4 Хэрэглэгч нэхэмжлэх илгээснээс хойш 10 хоногийн дотор төлбөрийг бүрэн төлөх бөгөөд төлбөрөө төлөөгүй буюу дутуу төлсөн бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,5 хүртэлх хувийн алданги төлнө. Энэ нь төлөөгүй үнийн дүнгийн 50%-иас хэтрэхгүй байна. /Гуравдагч этгээдээр дамжуулан тушаасан мөнгөтэй холбогдон гарах маргааныг хангагч тал хариуцахгүй./
- 4.5 Хангагчийн эрх бүхий ажилтан тухайн хэрэглэгчийн тоолуурын лац, ломбоны бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хянаж, сард тоолуурын бичилт, тооцооны хуудас дээр параметрийг тэмдэглэж, хэрэглэгчийн эрх бүхий төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажуулсан хуудсыг үндэслэн сарын төлбөрийг тооцно.
- 4.6 Хэрэглэгч сүлжээний буцах усны халууныг батлагдсан графикаас 4-өөс дээш хэмээр өндөржүүлсэн тохиолдолд өндөржүүлсэн хэмд ногдох ашиглахгүй буцаасан дулааны эрчим хүчний үнийг тооцож, буцах усны температур өндөржсөнд ногдох дулааны төлбөрийг тухайн сарын төлбөр дээр нэмж төлөх үүрэг хүлээнэ.
- 4.7 Хэрэглэгчийн буруугаас нэмэлт ус зарцуулсан бол дулааны тоног төхөөрөмж дээр суурилуулсан нэмэлт усны тоолуурын заалтыг үндэслэн нэмэлт устай хамт алдагдаж байгаа дулааны энерги болон нэмэлт усны төлбөрийг хэрэглэгчээс тооцон авна.
- 4.8 Хэрэглэгч эзэмшлийн заагаар өөрийн хэсэгт тавигдсан дулааны тоолуур, хэмжих хэрэгслийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дурмэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан, тоолуур гэмтэлтэй байгаа нь тогтоогдвол төлбөр тооцоог хангагч уг барилга объектын зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн /задгайгаар/ нөхөн тооцно.
- 4.9 Талууд гэрээний хугацаа дуусахад дулааны эрчим хүчний борлуулалт, төлбөрийн санхүүгийн тооцоог нийлж, хамтарсан актаар баталгаажуулж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна.

ТАВ. ТАЛУУД ХООРОНДЫН БУСАД ХАРИЛЦАА

- 5.1 Стандартын шаардлага хангаагүй дулааны эрчим хүч нийлүүлж, хохирол гарсан тохиолдолд хоёр талын төлөөлөгч байлцан шалтгааныг тодруулан хамтарсан протокол үйлдэж баталгаажуулна.
- 5.2 Энэхүү гэрээ болон түүний хавсралт хэсэгт өөрчлөлт орох бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа талууд албан бичгээр ирүүлэх бөгөөд асуудлыг хоёр тал хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Гэрээний нэмэлт өөрчлөлт дээр талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр болно.
- 5.3 Хэрэглэгч тал энэхүү гэрээний дагуу дулаанаар хангагдаж байгаа барилга байгууламжийн өмчлөлийн эрхийг бусдад шилжүүлэх болон бусад шалтгаанаар гэрээ цуцлах бол эзэмшилд байх үед үүссэн өр төлбөр, бусад асуудлыг бүрэн шийдвэрлэж гэрээ цуцлах тухай албан бичгээр хүсэлт ирүүлнэ.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Хангагчаас гэрээний үүргийн биелэлттэй холбоотой өгсөн албан шаардлагын хугацаанд зөрчлөө арилгаагүй бол гэрээнд тусгагдсан мэйл хаягаар болон утасны дугаарт дулааныг түдгэлзүүлэх тухай мэдэгдэл өгч, дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 6.2 Гэрээний талаар маргаан гарвал талууд маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Хэрэв харилцан тохиролцож чадаагүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Хангагчийг төлөөлж:

Бизнес үйлчилгээ эрхэлсэн
Дэд захирал Б.Сандуйжав

БМА-ны дарга С.Алтанхуяг

СБХ-ийн дарга бөгөөд Ерөнхий ня-бо
..... Д.Төмөртоогоо

Хуулийн зөвлөх Ч.Бямбасүрэн

Гэрээний мэргэжилтэн
..... С.Донид

РД:2688352

Харилцах банк:ХХБ 806-р салбар

Дансны дугаар: 406001049

Харилцах банк: Төрийн банк

Дансны дугаар:102100001107

Харилцах банк:ХААН банк

Дансны дугаар:5038008126

Хэрэглэгчийг төлөөлж:

Үйлдвэрийн дарга.....

..... А.Ганбаях

Нягтлан бодогч..... Б.Дүүриймаа

РД:5140447

Харилцах банк:

Дансны дугаар:

Харилцах банк:

Дансны дугаар:

Харилцах банк:Голомт банк

Дансны дугаар:1102038052

Цахим хаяг:sales@tpp4.mn

Харилцах утас:7000-2245

7017-0783

7000-1184

Байршлын хаяг:

Баянгол дүүрэг 20-р хороо

Эрчим хүчний гудамж

Нэхэмжлэх хүлээн авах

албан ёсны и-мэйл хаяг:

duurii_0822@yahoo.com

Харилцах утас:

99107949

99069427-нябо

Байршлын хаяг:

Баянгол дүүрэг 20-р хороо

Үйлдвэрлэлийн бүс

4/2020-566

.....тоот гэрээний хавсралт №

БҮТЭЭГДХҮҮНИЙ ЗАХИАЛГЫН ХУУДАС

Худалдан авагч

1. Дулааны эрчим хүчний бүтээгдхүүн худалдан авах барилга, объектын тооцоот ачаалал

№	Барилга объектын нэр	Хэрэглээ	Тооцоот ачаалал	Эзэлхүүн талбай, хүний тоо	Хэмжүүрийн дугаар	Дулаан авах эхний он сар өдөр	Дулаан хаах он сар өдөр
1		Халаалт	М.куб				
2							
3							
	ДҮН						
		Халуун ус	Гкал				
		Хүйтэн ус	Хэмжүүрийн заалтаар				
		Бохир ус					

2. Бүтээгдхүүний хэмжээ

№	Бүтээгдхүүн худалдан авах сар	Халаалт		Халуун ус		Тухайн сард төлөх нийт дүн төгрөг
		Тоо хэмжээ М.куб	Мөнгөн дүн төгрөг	Тоо хэмжээ Гкал	Мөнгөн дүн төгрөг	
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						

Жич: Тоолууртай хэрэглэгчдийн тооцоог тухайн сарын тоолуурын заалтыг үндэслэн төлбөрийг тооцно.

Худалдагч талыг төлөөлж:

Худалдан авагчийг төлөөлж

БМА-ны борлуулалтын менежер

.....

 Д.Гантөмөр